



## МОНГОЛУЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2001 оны 6 дугаар  
сарын 20 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

**"Дарцагт" Нийслэлийн өмчит  
үйлдвэрийн газар байгуулах тухай**

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2000 оны 37 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Өмчийн харилцааны газарт төвлөрүүлж байгаа малыг түшиглэн Нийслэлийн Туслах аж ахуйн чиглэлээр ажиллах "Дарцагт" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /НӨҮГ/-ыг байгуулж дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. "Дарцагт" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Навааншаравын Чулуунжавыг 2001 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн томилж сарын үндсэн цалинг 80000 /наян мянга/ төгрөгөөр тогтоосугай.

Гурав. Малын тоо толгойг өсгөх, ашиг шимийг дээшлүүлэх, туслах аж ахуйг үр өгөөжтэй ажиллуулах талаар бизнес төлөвлөгөө гаргаж хянуулан, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/, "Дарцагт" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /Н.Чулуунжав/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Шинээр байгуулагдаж байгаа үйлдвэрийн газрын үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах 10,3 сая төгрөгийг ногдол ашгийн орлогоос олгохыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /П.Дэлгэрнаран/-т, Хотын Санхүүгийн бодлогын хэлтэс /Д.Ганболд/-т зөвшөөрсүгэй.

Тав. Дээрхи заалтаар олгогдох 10,3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж үр дүнг 2001 онд багтаан танилцуулахыг "Дарцагт" Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар /Н.Чулуунжав/-т үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны  
 . 311 ... тоот захирамжийн хавсралт

**“ДАРЦАГТ” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИГ ҮЙЛДВЭРИЙН  
 ГАЗРЫН /УУГ/ ДҮРЭМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 “Дарцагт” Нийслэлийн Өмчит үйлдвэрийн газар нь (цаашид газар гэнэ) Нийслэлийн нэгдсэн туслах аж ахуйг тодорхой бодлого, төлөвлөгөө, хэтийн зорилго чиглэлтэйгээр удирдан зохион байгуулах үүрэг бүхий улсын үйлдвэрийн газар юм.

1.2 Газрын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон Оролцогчийн Өмчийн тухай хууль, Нөхөрлөл, Компанийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр зэргийг удирдлага болгоно.

1.3 Газрын зорилго нь: Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэн явуулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Нийслэлийн төр, захиргааны байгууллагыг хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, ажилчин, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэхэд оршино.

1.4 Газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.5 Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.6 Газрын оноосон нэр нь “Дарцагт” бөгөөд төв нь Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн I хорооны нутаг дэвсгэрт байрлана. Утас: 328133

**Хоёр. Удирдлагын зохион байгуулалт**

2.1 Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч томилж чөлөөлнө.

2.2 Газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өмнө ажлаа тайлагнана.

2.3 Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч баталж, бүтэц орон тооны хязгаарт Өмчийн харилцааны газар хяналт тавина.

2.4 Газрын захирал нь байгууллагын бүтэц, дотоод журам, орон тоо, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба ажилчин, албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.5 Газрын захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж эзэмшинэ.

2.6 Газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвшилцөх үүрэг бүхий захирлын дэргэдэх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг, газрын захирал тушаалаар батална. Зөвлөлийн гишүүд гагцхүү зөвлөх эрхтэй байна.

2.7 Газрын захирлын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулан ажиллана.

### **Гурав. Газрын үүрэг**

3.1 Туслах аж ахуйн техник зохион байгуулалтын болон эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэтийн чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2 Өөрийн аж ахуйн мэдэлд байгаа мал сүргийн тоо толгойг өсгөн, ашиг шимийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, таварлаг аж ахуй болон хөгжүүлэх ажлыг Нийслэлийн засаг дарга, Өмчийн харилцааны газраас өгсөн үүрэг, зорилт, чиглэлийн дагуу зохион байгуулж ажиллана.

3.3 Газар нь шинжлэх ухаан, техникийн дэвшил, шинэ техник, технологийг салбарын хэмжээнд нэвтрүүлэх, энэ чиглэлээр заавар, зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулан чиглэл өгч ажиллана.

3.4 Газар нь тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан болох бүртгэлийн болон бусад санхүүгийн холбогдолтой хууль, дүрэм, журам заавар, үнэ тарифийг мөрдүүлж ажиллана.

3.5 Газар нь мал аж ахуй, газар тариалангийн салбарыг хөгжүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх, хашаа худаг засварлах, сэргээн босгох асуудлаар хөтөлбөр боловсруулан ажиллана.



3.6 Газар нь салбарын үйл ажиллагаатай холбоо бүхий асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн төсөл боловсруулах, тэдгээрт санал өгөх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих ажлыг зохион байгуулна.

3.7 Маргаантай асуудлаар туслах аж ахуйгаа төлөөлж, шүүхэд нэхэмжлэл гаргах ба хууль, хяналтын байгууллагад хандана.

3.8 Монгол улсын холбогдох хууль тогтоомжинд заасан бусад үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Газрын эрх**

4.1 “Дарцагт” НӨҮГ-ыг байгуулах шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцож, нөхөрлөл, компанийн хуулинд заасан журмаар бүртгүүлж, хуулийн этгээдийн эрхтэй болно.

4.2 Газар нь өөрийн нэрийн өмнөөс гадаад дотоодын байгууллагуудтай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн шүүх арбитрын байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

4.3 Газар нь ажлын шаардлагаас өөрийн харьяанд аж ахуйн нэгж, цэг салбар нээж ажиллуулах, татан буулгах, хуулийн дагуу харьяа салбартай байж болно.

4.4 Хөдөө аж ахуйн болон автомашины тоног төхөөрөмж, шатах тослох материал, малын хашаа саравчны модон материал, эм тариа зэргийг галаад, дотоодын зах зээлээс худалдан авч, бие даан хэрэглэнэ.

4.5 Захирал нь “Төрийн өмчийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 16, 20-р зүйлд заасан хөрөнгийн талаарх эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.6 Захирал нь “Төрийн өмчийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн тавдугаар бүлэгт заасны дагуу Төрийн өмчийг эзэмшиж ашиглах ба захиран зарцуулна.

4.7 Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, тооллого, тооцоо бүртгэл хөтлөлтөнд хяналт тавьж, үндсэн хөрөнгийг шинээр худалдан авах болон ашиглалтаас хасах асуудлыг Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтран шийдвэрлэнэ.

4.8 Ажил үйлдвэрлэл явуулсны үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж, захиран зарцуулна.

4.9 Малын ашиг шимийг ашиглах замаар айраг, сүү цагаан идээг үйлдвэрлэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Өмчийн харилцааны газрын гуанз, цайны газрын хэрэгцээг хангах зорилгоор бэлтгэн нийлүүлэх, илүүдэл бүтээгдэхүүнийг худалдаж борлуулна.

4.10 Төмс, хүнсний ногоо, ногоон тэжээл тариалах, хадлан тэжээл халаж бэлтгэхээс гадна малын арьс шир, ноос, ноолуур, айраг сүү, махыг мухлагаар худалдаж, гуанз, цайны газрын үйлчилгээг явуулна.

4.11 Гадаад, дотоодын холбоглох байгууллагуудтай тогтоосон журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллахын зэрэгцээ гадаад, дотоод худалдаа эрхэлнэ.

### **Тав. Эд хөрөнгө санхүүгийн бүртгэл, хяналт**

5.1 Газрын эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол улсын Нягтлан бодох хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

5.2 Газрын санхүүгийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхэлж, хуаплийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

5.3 Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.4 Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.5 Газар нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.6 Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжинд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.7 Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.8 Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон бапкинд хадгалагдаж буй мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.



5.9 Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах боловч худалдах, хувьчлахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д заасан журмыг баримтална.

### **Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах**

6.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн санал болгосноор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

6.2 Газрыг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс уг ажлыг эрхэлнэ.

6.3 Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан тэнцэл гаргуулан, үүсгэн байгуулагчид танилцуулж, нийтэд мэдээлж, өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу төлөгдсөний дараа үндсэн хөрөнгийг 3 сарын дотор үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

### **Долоо. Хариуцлага**

7.1 Газрын албан хаагчид нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

7.2 Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийг захирамж, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.3 Газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлсэн буюу урвуулан ашиглаж байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохирлыг газрын дарга өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.

### **Найм. Бусад**

8.1 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2 Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.